



БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *С.С.С.* М.МӨНХӨӨ



БАТЛАВ
ХҮҮГИЙН ГУТАЛ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ *Г.Алтанхуяг* Г.АЛТАНХУЯГ

АЖЛЫН ГУТАЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

20²³ оны 04-р сарын 07-өдөр

Дугаар № 2023/2

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас “Хүүгийн гутал ХХК”-ийг төлөөлж захирал Г.Алтанхуяг /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь хэсэг, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

- 1.1 Нийлүүлэгч нь “Ажлын гутал” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрөл, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

- 2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 30 хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 33,770,000 / Гучин гурван сая долоон зуун далан мянга /-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль онцгой албан татвар, захиалагчийн агуулахад хүргэх тээврийн зардал, НӨАТ бүгд орсон байна.
- 3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгaa төлбөр төлөхгүй.
- 3.3 Барааг хүлээлгэн өгсөний дараа бараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Хаан банкны 5121037685 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хулээх хариуцлага

- 4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандaa нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа

төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

- 4.3 Барааг захиалагчийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана. Буцаах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 4.4 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Хангамжийн хэлтсийн цахим худалдан авалт хариуцсан ажилтан Б.Дуламсүрэн хариуцан ажиллана. Утас-88015890.
- 4.5 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Хүүгийн гутал ХХК-ийн захирал Г.Алтанхуяг хариуцан ажиллана. Утас- 99111451.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.3 Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой үйлдвэрийн доголдолоос гарсан барааны гологдол зэрэг шаардлагад нийцээгүй ажлын хувцасыг буцаан өөрийн зардлаар засаж, залруулах үүрэгтэй.
- 5.4 Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 6 сарын баталгаа гаргана.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Нийлүүлэгч нь барааг энэхүү гэрээний 2.1-т заасан материал нийлүүлэх хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.
- 8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ec. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Г.БАТТУЛГА

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

П.ЗОРИГОО

ХУУЛИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ЦАХИМ ХУДАЛДАН АВАЛТ
ХАРИУЦСАН АЖИЛТАН

Б.ДУЛАМСҮРЭН

Хаяг: Монгол улс, Улаанбаатар
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХҮҮГИЙН ГУТАЛ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Г.АЛТАНХУЯГ



Хаяг: УБ хот СБД дүүрэг 16-р хороо
Бэлх гудамж-130
Утасны дугаар: 99111451
РД: 5501741

..... Тоот гэрээний хавсралт

Бараа нийлүүлэх үнийн санал

№	Бараа материалын нэрс	Гарал үүслийн улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ /НӨАТ/-эй
1	Ажлын гутал /өвлийн /	Монгол	Хос	70	160,000	12,320,000
2	Ажлын гутал /зуны /	Монгол	Хос	130	150,000	21,450,000
Нийт						33,770,000

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ЦАХИМ ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН



Б.Нямжигүүл

Б.ДУЛАМСҮРЭН

Г.Алтанхуяг

ХҮҮГИЙН ГУТАЛ

ХХК-ИЙН ЗАХИРАЛ

ХТНСОЧ 35531741

1.17.2014

БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦТӨХХИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(СССР 88)

М.МОНХӨӨ

АЖЛЫН ГУТАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлын тусгай гутал – Ерөнхий шаардлага MNS 5623:2006 стандарт болон ХАБЭА-н үндэсний хорооны 2021 оны 01-р тогтоолоор гарсан зөвлөмжийн дагуу ажилчдад олгох ажлын гутал нийлүүлэх компани үйлдвэрлэл дээр дараах чанарын шаардлагыг хангасан байвал зохино.

ЗУНЫ ГУТАЛ:

1. Өдөр тутам өмсөх зориулалттай.
2. Урт түрийтэй болон үдээстэй
3. Ул нь +300 °C халууныг тэсвэрлэх, зузаан, халтиргагүй, хугардаггүй шахмал резинэн материалыар хийсэн
4. Хөлийн анатомийн бүтцэд нийцсэн хэвтэй
5. Хуруу, шагайн хамгаалалттай, 200 Дж хүртлэх хэмжээний цохилтын хучийг даах тэсвэртэй, хамрын хатуулгыг хөнгөн жингэй мателлаар хийсэн байх
6. Доргионы хамгаалалт, халтиргаа, ус тосонд тэсвэртэй, давхар оёдолтой, турд хэсэг нь ширээр хийгдсэн.
7. Хөлд хөнгөн эвтэйхэн, хуурай орчинд илүү тохиромжтой, Чийгтэй орчинд удаан өмсөхөд хамгаалах чанартай
8. Агаар нэвтрүүлдэг арьсан, цахилгааны болон хурц ир, үзүүртэй зүйлийн хүчлэлд орохгүй зузаан зөөлен,
9. Үдээсний темэр тоногууд нь зэвэрдэггүй, өмсөх, тайлахад хялбар
10. Механик уртэс тоос шороо орохгүй ургэлж хэлтэй, зуузайны хатуулгатай байна.
11. Резмерийн сонголт 36-45 хүртэл
12. Хажуу талдаа цагаан оруулга бүхий гэрэл ойлгогчтой

ӨВЛИЙН ГУТАЛ:

1. Урт түрийтэй, үдээсгүй болон үдээстэй
2. Арьс болон ширэн, хөлд эвтэйхэн, ядраахгүй зөөлен, үстэй дотортой
3. Ул нь -50 °C - +300 °C -ийг тэсвэрлэх, ул нь хөлдөхгүй хугарахгүй, зүсэгдэхгүй, хальтрахгүй, нэхий дотортой
4. Хөлд хөнгөн эвтэйхэн, хуурай орчинд илүү тохиромжтой, Чийгтэй орчинд удаан өмсөхөд хамгаалах чанартай
5. Хөлийн анатомийн бүтцэд нийцсэн хэвтэй
6. Хуруу, шагайн хамгаалалттай, 200 Дж хүртлэх хэмжээний цохилтын хучийг даах тэсвэртэй, хамрын хатуулгыг хөнгөн жингэй мателлаар хийсэн байх
7. Уландаа завсарын ган давхаргатай
8. Шагайны зөөлөвчтэй, хөл хуруу ёсгийг холгохоос сэргийлсэн, давхар оёдолтой
9. Усны хамгаалалттай, цахилгаан дамжуулахгүй ус тосонд тэсвэртэй чийг татахгүй, дулаахан
10. Хөлд хөнгөн эвтэйхэн, хуурай орчинд илүү тохиромжтой, Чийгтэй орчинд удаан өмсөхөд хамгаалах чанартай

11. Агаар нэвтрүүлдэг арьсан, цахилгааны болон хурц ир, үзүүртэй зүйлийн хүчлэлд орохгүй зузаан зөөлөн,
12. Резмерийн сонголт 36-45 хуртэл
13. Хажуу талдаа цагаан оруулга бүхий гэрэл ойлгогчтой

Ажлын өвөл зуны гутал

	Түрийтэй / өвөл/	Үдээстэй / өвөл/	Түрийтэй / зун/	Үдээстэй / зун/
Зуухан цех / Ашиглалт /		+		+
Зуухан цех / Засвар /	+		+	
ТДЦех / Ашиглалт /	+			+
ТДЦех / Засвар /	+		+	
Авто хэсэг	+		+	
ДХХА хэсэг		+		+
РХА		+		+
Хими хэсэг		+		+
Цахилгаан		+		+

Тусгай шаардлага:

1. Тендерт оролцож буй оролцогч нь ажлын тусгай гуталны загваруудын дээжийг авчирч шалгаруултанд оролзох
2. Тухайн тендерт шалгарсан оролцогчын материалын дээжийг буцаахгүй.
3. Тендерт шалгарсан тохиолдолд ажлын тусгай гуталны загварыг урьдчилсан захиалагчид танилцуулж, үйлдвэрлэх зөвшөөрөл авна
4. Ажлын гутал нь стандартын гэрчилгээ /сертификат/-тай байх. Байхгүй бол ХАБЭА тухай хуулийн 15.4-т заасанчилан мэргэжлийн байгууллагын дүгнэлтэй байна.
5. Стандартын дагуу үйлдвэрлэсэн эсэхийг хөндлөнгийн лаборторит шинжлүүлсэн байх

ХЯНАСАН:

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

П.ЗОРИГОО

ШААРДЛАГА БИЧСЭН:

ХАБЭА-Н ИНЖЕНЕР

А.ЭНХЖАРГАЛ